



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/35/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
	Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Багийн ахлагч аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: munkhtogtokht@audit.gov.mn
	Гэрээт аудитор:	М.Дүүрэнжаргал
		Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гуламж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

Додд. 02.25 № 16/195
танай _____ -ны № _____ -т

ЗАМЫН-ҮҮД СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА А.АНХТУЯА ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Замын-Үүд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар хариуцлага тооцох албан шаардлагыг хэрэгжүүлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга А.Анхтуяад Засаг даргын 2021 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн А/10 захирамжаар “сануулах” сахилгын шийтгэлийг ногдуулсан бөгөөд 2021 оны 12 дугаар сард үр дүнгийн урамшуулал болох 1.4 сая төгрөгийг олгосон байна. Мөн албан томилолтоор ажилласан албан хаагчдад хоол, унааны хөнгөлөлтийг давхардуулан олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 2.7-д “Хууль тогтоомжийн дагуу сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн сахилгын шийтгэлгүйд тооцогдох хугацаа дуусаагүй бол тухайн төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгохгүй.”, Хөдөлмөрийн тухай хуулийн 123.5-д “...сахилгын зөрчил гарсан өдрөөс, эсхүл зөрчил үргэлжилсэн тохиолдолд зөрчил гаргасан сүүлийн өдрөөс хойш нэг жилийн дотор хөдөлмөрийн сахилгын шийтгэл ногдуулна”, Төсвийн тухай хуулийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын 2.2-т “Албан томилолтоор ажиллах үеийн нөхөх төлбөрт ..., хоолны зардал зардлаас бүрдэнэ” зэрэг заалтуудыг зөрчиж, үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Тайлант онд ном хэвлэл зардлаас 0.01 сая төгрөгийг шуудангийн үйлчилгээнд, бусад бараа үйлчилгээний зардлаас 0.5 сая төгрөгийг бичиг хэргийн зардалд, 0.1 сая төгрөгийг сүлд худалдан авах зардалд, 2.8 сая төгрөгийг автомашины сэлбэгийн төлбөрт, бага үнэтэй

түргэн элэгдэх, аж ахуйн материал зардлаас 4.5 сая төгрөгийг урсгал засварын материалын зардалд тус тус зарцуулж, нийт 9.5 сая төгрөгийн төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "Батлагдсан төсвийн зориулалтын дагуу зарцуулах", Засгийн газрын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчиж, ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	3.6	7.0
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	59.9	57.2
	Нийт хөрөнгийн дүн	63.5	64.2
	Нийт өр төлбөрийн дүн	-	1.9
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	63.5	62.3
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	63.5	64.2
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	180.2	219.8
	Үйл ажиллагааны зардлын дүн	178.3	221.0
	Үйл ажиллагааны үр дүн	1.9	(1.2)
	Үйл ажиллагааны бус үр дүн	-	-
	Үйл ажиллагааны нийт үр дүн	1.9	(1.2)
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-
	Тайлант оны үр дүн	1.9	(1.2)
	Эцсийн үлдэгдэл	63.5	62.3
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	180.2	219.8
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	180.2	218.6
	Үйл ажиллагааны ЦМГ	-	1.2
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	(1.2)
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ		
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлан			
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	132.4	172.2
	Урсгал зардал	132.4	172.2
	Хөрөнгийн зардал	-	-
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	132.4	172.2
	Орон нутгийн төсвөөс санхүүжих	132.4	172.2

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын үйл ажиллагааг хэрэгжүүлэн ажилладаг бөгөөд тайлант онд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Монгол Улсын хуулиудад заагдсан эрх, үүргийн биелэлтийг ханган нутгийн өөрөө удирдах ёсны чадавхийг бэхжүүлэх, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийн байдалд төлөөлөгчдөөр дамжуулан иргэдийн хяналт, оролцоог дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийн баталгааг бий болгох бодлого шийдвэрийг боловсруулан хэрэгжүүлэх, эдийн засаг,

нийгмийн тулгамдсан асуудлыг иргэдийн нийтлэг эрх ашигт тулгуурлан шийдвэрлэж, орон нутгийн тогтвортой хөгжлийг хангах зорилгын хүрээнд зорилго тавьж, ажилласан байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсөвт байгууллага нь Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 390 дугаар тушаалын жишиг нормоос хэтрүүлсэн зарцуулсан бөгөөд бодит гүйцэтгэлийг илэрхийлэх шатахууны норм баталсан тушаал үйлдээгүй байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар дэлгэрэнгүй бүртгэл болон бусад баримт мэдээллийг шалгахад тус байгууллага нь тайлант онд цалингийн зардлаас бусад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 49.4 сая төгрөгийн 7 орлогын гүйлгээ, өмч хөрөнгө, төсөв зарцуулах 21.1 сая төгрөгийн 33 тушаал, шийдвэрийг байршуулахаар байна.

Дээрх мэдээллийг шилэн дансны цахим системд байршуулсан мэдээлэлтэй тулган шалгахад 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 31.4 сая төгрөгийн 4 орлогын гүйлгээг, 2.9 сая төгрөгийн 4 тушаалыг огт байршуулаагүй байна.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

Төсвийн гүйцэтгэлийн мэдээ, санхүүгийн тайлан, аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг шилэн дансны цахим системд хуулиар тогтоосон хугацаанд, бүрэн байршуулсан байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Арилжааны банкинд байрших харилцахын түр дансны орлого, зарлагын гүйлгээг тушаалын дагуу хийсэн эсэх, үлдэгдэлтэй эсэх, бэлэн мөнгөний кассын журмыг баримталж ажилласан эсэхийг зайлшгүй авч үзэх шаардлагатай.

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 47.2 сая төгрөгийн 9 алдаа зөрчил илэрснээс, 27.1 сая төгрөгийн 1 алдааг залруулж, залруулагдаагүй алдаа зөрчлөөс 4.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж, 13.3 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 2.8 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн актыг хүргүүлсэн.

Залруулсан алдаа:

1. Ерөнхий журналаас зардал тус бүрээр шүүж үзэхэд 27.1 сая төгрөгийн 86 гүйлгээг буруу дансанд тайлагнасан байсныг аудитын явцад залруулав.

Зөвлөмж:

1. Зам, тээврийн хөгжлийн сайдын 390 дугаар тушаалаар баталсан жишиг нормоор 4000 хөдөлгүүрийн багтаамжтай LAND-200 маркийн автомашин нь 11.9л/100 км байна. Төсөвт байгууллага нь 21.5л/100 км зарцуулалттайгаар зам хуудсыг бөглөдөг бөгөөд нийт 4.0 сая төгрөгийн шатахууны зөрүү үүссэн байна.
2. Касс харилцахын баримтыг түүврээр шалгахад зардлын ангилал андуурагдаж хийгдсэн 1 гүйлгээ, анхан шатны баримтгүй 5 гүйлгээ, төлбөрийн хүсэлтгүй 2 гүйлгээ байна. Анхан шатны баримтгүй гүйлгээг тодруулж, ярилцлага хийсэн бөгөөд 4 гүйлгээний баримтыг гаргаж өгсөн. 1 гүйлгээний тушаалыг олоогүй.

Албан шаардлага:

1. ЗГ-ын 43 дугаар тогтоолоор батлагдсан хэмнэлтийн арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан эсэхэд дүн шинжилгээ хийхэд 1.6-д заасныг зөрчиж, Үндсэн хуулийн 30 жилийн ойн шатрын тэмцээнийг 0.3 сая төгрөгөөр санхүүжүүлж зохион байгуулсан. Мөн 1.7-д заасныг зөрчиж, 0.2 сая төгрөгийн хүчирхийллийн эсрэг видео танилцуулга, 0.2 сая төгрөгийн лого хийлгэсэн байна.
2. Бэлэн мөнгөний үлдэгдлийг тайлагнаагүй, мөн бэлэн мөнгөний тооллогыг хийгээгүй, баримжуулж баталгаажуулаагүй.
3. Мөнгөн гүйлгээний журналаас зардал тус бүрээр шүүхэд ном хэвлэл зардлаас 0.01 сая төгрөгийн шуудангийн үйлчилгээ, бусад бараа үйлчилгээний зардлаас 0.5 сая төгрөгийн ажлын албаны бичиг хэргийн материалыг, 0.1 сая төгрөгийн сүлдийг худалдан авсан, 2.8 сая төгрөгийн автомашины сэлбэгийн төлбөрийг, бага үнэтэй түргэн элэгдэх аж ахуйн бараа зардлаас 4.5 сая төгрөгийн урсгал засварын барааны үнийг тус тус зарцуулсан бөгөөд хөтөлбөр арга хэмжээ андуурсан 1.4 сая төгрөгийн гүйлгээ байна.
4. 5.0 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 53.2 сая төгрөгийн 5 гүйлгээ, 5.8 сая төгрөгийн 1 зарлагын гүйлгээ, 10.8 сая төгрөгийн 2 худалдан авалтын гүйлгээг мэдээлээгүй бөгөөд нийт 2.2 сая төгрөгийн 6 шийдвэрийг байршуулаагүй, 7 шийдвэрийг хугацаа хоцроосон байна.

Төлбөрийн акт:

1. Цалингийн тооцооллын хүснэгтийг нэмэгдэл баталсан тушаалтай тулгахад А.Анхтуяад ЭБАТ-ын нэмэгдлийг 40% -аар тооцон 0.03 сая төгрөгийг илүү олгосон, мөн 2021 оны 3 дугаар сарын 30-ны А/10 захирамжаар "сануулах" сахилгын шийтгэл ногдуулсан байхад 2021 оны 12 дугаар сарын 15-ны Б/01 тушаалаар үр дүнгийн урамшуулал олгох тушаалын дагуу 1.4 сая төгрөгийг олгосон байна. Томилолтоор ажилласан 3 ажилтанд 0.1 сая төгрөгийн хоол унааны хөнгөлөлтийг илүү тооцож олгосон байна.
2. Арилжааны банкин дахь Засаг даргын Тамгын газрын түр дансаар урамшууллын бэлэн мөнгийг дамжуулан авдаг бөгөөд дансны хуулгыг шүүж үзэхэд 1.2 сая төгрөгийг үлдэгдэлтэй байна.

6.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ								
5	ТЕЗ								
	НИЙТ								

6.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ТШЗ	9	47.2	1	27.1	2	2.8	4	13.3	2	4.0
2	Төсөл, хөтөлбөр										
3	ЗГТС										
4	ТТЗ										
5	ТЕЗ										
	НИЙТ	9	47.2	1	27.1	2	2.8	4	13.3	2	4.0